



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/510

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."г", Төсвийн тухай хуулийн 14.2.3.заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын харьяат Жүгдэрнамжил овогтой Отгонжаргал нь 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт кесерево хагалгаанд орсон бөгөөд улмаар төрсөн эхийн биеийн байдал хүндэрч, эхийн амь насыг аврах заалтаар Улаанбаатар хотын Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв рүү яаралтай илгээх болсон тул авч явах эмч болон үйлчлүүлэгчийн замын зардал болох 898,000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх 898,000 (Найман зуун ерэн мянган) төгрөгийг "Эрүүл иргэн-Эрхэм баялаг" дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Базар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Азжая) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

